

Австралийн Элчин сайдын яамны санхүүжилттэй бичил төслийн туршлагаас хуваалцлаа

<http://ardchilal.mn/15990.html>

НИЙТЛЭСЭН: 2017-06-15 15:45:23

Улс төр > Засгийн газар | Сэтгэгдэл: 14



Австрали Улсын Элчин сайдын яам жил бүр нийт 240 мянган долларын санхүүжилттэй “Бичил төслийн хөтөлбөр” хэрэгжүүлдэг юм байна. Өнгөрсөн жил санхүүжилт авсан 10 төрийн болон ТББ-ын төлөөлөгчид төсөл хэрэгжүүлсэн туршлагаа хуваалцах уулзалт, хурал зургаадугаар сарын 15-ны өдөр Улаанбаатар зочид буудалд боллоо. Энэ үеэр бичил төслийн хөтөлбөрийн 2018 оны шалгаруулалт явагдаж байна.

Уг хөтөлбөрийг Монгол Улсад суугаа Австрали Улсын Элчин сайдын яам чиглүүлж, зохион байгуулдаг аж. Австрали Улсын хөгжлийн буцалтгүй тусламжийн нэг хэсэг болох Бичил төслийн хөтөлбөр нь Монгол Улсын тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах, ядуурлыг бууруулах чиглэлээр Монголын иргэний нийгэм, байгууллагууд төсөл санаачлан хэрэгжүүлэхэд санхүүжилтийн дэмжлэг үзүүлдэг юм байна.

2013 оноос хойш Монголд тус хөтөлбөрийн дэмжлэгтэй 100 гаруй байгууллага нийтдээ 113 төсөл санаалан хэрэгжүүлжээ. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд боловсрол, эрүүл мэнд, байгаль орчны хамгаалал, эмэгтэйчүүдийн эрх, хүйсийн эрх тэгш байдал, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих, хүний эрх, өрхийн амьжиргаа, хөдөө аж ахуй болон залуучуудын оролцоо, хүмүүнлэгийн зэрэг олон чиглэл салбарыг хамарсан төсөл хэрэгждэг юм байна.



Өнөөдрийн төсөл танилцуулах уулзалтаар тусгай хэрэгцээт хүүхдүүдийн боловсрол, хүйсийн болон гэр бүлийн хүчирхийллийн эсрэг, гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдыг байршуулж, хамгаалах, эмэгтэйчүүдийн эдийн засгийн чадавхийг дээшлүүлэ болон залуучуудын хөгжил зэрэг төслийг хэлэлцэв.

Б.Баярмаа